



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2025.03.14 № 86

танай _____-ны № _____-т

ЖАРГАЛАНТ УС ДУЛААН ТҮГЭЭХ
СТАНЦ ОНӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРЛЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ
П.ЭНЭМОНОО ТАНАА

Дүгнэлт өгөхөөс татгалзсан

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Жаргалант ус түгээх станц ОНӨХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийхээр төлөвлөсөн.

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд дүгнэлт өгөхөөс татгалзаж байна. Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь санхүүгийн тайланд материаллагаар нөлөөлсөн ба өргөн тархсан гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд дүгнэлт өгөх хангалттай, зохистой аудитын нотолгоо олж авах боломжгүй байна

Дүгнэлт өгөхөөс татгалзсан үндэслэл

Жаргалант ус дулаан түгээх станц ОНӨХК нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг 2025 оны 02 дугаар сарын 28-ны өдөр 05 дугаартай албан бичгийн хамт ирүүлсэн боловч санхүүгийн анхан шатны баримт, материалыг 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдрийг хүртэл ирүүлээгүй нь тайланд дүгнэлт өгөхөд хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авах цаг хугацааг хязгаарлаж байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 4.1.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 14-д заасантай нийцээгүй, Санхүүгийн тайлангийн аудитын “Эрх ба үүрэг”, “Тохиолдсон байх”, “Иж бүрэн байх”, “Хэмжилт”, “Тасалбар болголт” батламж мэдэгдэлүүдийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой байсан.

Гэвч, дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн улмаас санхүүгийн тайланд дүгнэлт өгөхөд үндэслэл болохуйц хангалттай бөгөөд зохистой нотолгоо авах боломжгүй байна.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

The image shows a handwritten signature in black ink over a red official stamp. The stamp is rectangular and contains the Mongolian text 'МОНГОЛЫН АУДИТ АГУУГА' (State Audit Agency of Mongolia) and 'УЛСЫН АУДИТ АГУУГА' (National Audit Agency) along with a central emblem.

П.ПҮРЭВЛХАГВА